

АРДЫН ХУВЬСГАЛЫН 53 ЖИЛИЙН ОЙ МАНДУГАЙ

Орх бусныг пролетариат нар нэгдэгтүн! АНХ ДУГААР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Хын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жилдээ

№ 52 (2316)

1974 оны 7 дугаар сарын 11

ПҮРЭВ

ЭРХ ЖАРГАЛЫН ИХ БАЯР

Октябрийн социалист их хувьсгалын нөлөөгөөр ялан мандсан Монгол ардын хувьсгалын түүхт 53 жилийн ойн баярыг тус аймгийн хөдөлмөрчид бүх ард түмнийхээ нэгэн адил ах дүү анд сайн нөхдийн хамт баяр байсгалантай ёслол тэмдэглэж байна.

Манай энэ түүхт баяр МАХН-ын III их хурал хуралдсаны боловч БНМАУ-ыг тунхагласны яруулдарт 50 жилийн ойг угтсан бүтээлч хөдөлмөрийн их өрнөлтийн үед болж байна.

МАХН-ын удирдлага, дэлхийн коммунист хөдөлгөөн, их Лениний нам, оросын ард түмний интернационалч ах дүүгийн тусламжтайгаар ялж мандсан 1921 оны ардын хувьсгал манай ард түмэнд эрх чөлөө туугаар тогтнолыг олгож, түүхэн хөгжлийн шинэ эрин үеийг нээж өгсөн билээ. МАХН, хоцрогдсон орон ялсан пролетарийн орны тусламжтайгаар капитализмыг алгасан социализмд шилжих болох тухай аугаа их Лениний сургаалыг удирдлага болгож, феодалын хоцрогдсон монгол орныг түүхэн богино хугацаанд цэцэглэн хөгжсөн ХАА-аг үйлдвэрийн шинэ социалист улс болгон хувиргалаа.

Үүний үр дүнд БНМАУ-д социалист үйлдвэрлэлийн харилцаа бүрэн илж, нийгэм эдийн засаг, соёлын гүн гүнзгий өөрчлөлт гарч үндэсний ажилчин анги, ардын сэхээтэн, хоршоолсон малчдаар социалист монгол үндэстэн бүрэлдэн хөдөлмөрчдийн улс төр, ёс суртахууны бат нэгдэл тогтжээ. Манай ард түмэн социализмыг бүрэн байгуулж дуусгахад намны шинэ программ намныхаа XVI их хурлын түүхэн шийдвэр шинэ V жилийн төлөвлөгөөгөө амжилттай биелүүлж байна.

Тус аймгийн нийт хөдөлмөрчид зөвхөн сүүлийн 3 жилд нийт малаа 50 гаруй мянган толгойгоор нэмэгдүүлж, үйлдвэрүүд 3 жил хагасын бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөг давуулан, 1973 онд мал өсгөх хөдөлшгүй төлөвлөгөөг 100,3 хувиар биелүүлж арвин их ургац хураан авлаа.

Манай аймгийн хөдөлмөрчид түүхт ойнуудыг угтаж бүх ард түмний социалист уралдаанд авсан амлалт үүргээ нэр төртэй биелүүлж, малын зүй бусын хорогдлыг багасгаж, толгоо сайн бойжуулж, үр тариа, төмс, хүнсний ногоо тариалалтыг хугацаанд нь дуусгах зэргээр энэ оны эхний хагас жилийн төлөвлөгөөг амжилттай биелүүлсэн дүнгээр түүхт ойн бадраа угтлаа. Үүдэснийхээ их баярыг ёслол тэмдэглэхдээ манай ард түмэн амжилтаа бататгаж, шийдвэрлэгдээгүй асуудалд бүх анхаарлыг төвлөрүүлэн, цаашдын зорилтоо тодорхойлж, түүнийг хэрэгжүүлдэг сайхан удмалжлалтай юм. 1974 оны төлөвлөгөөг амжилттай биелүүлж 5 жилийн төлөвлөгөөний эцсийн жил-1975 оны төлөвлөгөөт зорилтыг бүрэн биелүүлэх үндэс суурийг баттай давих явдал нам, ард түмний одоогийн чухал зорилт юм. Сайхан хуралдсан МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурал, БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулган аймгийн намны XVI бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, мал таргалуулах, малын тэжээл бэлтгэх овоожоо, хаваржаа, хашаа худга, мал услах цэг барих, засч сэлбэх зэрэг өндийн бэлтгэлийн эртнээс бүрэн сайн хангах, малын зүй бус хорогдлыг эрс багасгах тэмцлийг улам эрчимжүүлж, үр тарианы арвин их ургац хураан авч үйлдвэр, ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөг давуулан биелүүлсэн шинэ амжилтаар МАХН-ын III их хурал болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн түүхт ойг угтгахаа.

ЧАНАР САЙТАЙ ТУШААВ

Баянцагаан сум—нэгдлийн хоньчин Н.Цэвэр-рэгзэн 1974 онд хариуцаа байдгаа эм хонь, ямаанаас гарсан төлийг 101,5—109 хувиар бойжуулж төлөвлөгөөт ноолуураа 100 хувь 1 дүгээр зэрэгт тушаав.

БАЯРЫН ЦАХИЛГААН

Курган мужийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ф.Князов, Зовлолт—Монголын найрамдлын нийгэмлэгийн Курган мужийн салбарын дарга П.А.Матвеев нар Ардын хувьсгалын 53 жилийн ойг тохиолдуулан аймгийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ц.Адъяа Монгол—Зовлолтийн найрамдлын нийгэмлэгийн тус аймгийн Зовлолтийн дарга Х.Билгээ нарт баярын цахилгаан ирүүлэв.

Уг цахилгаанд Монгол Ардын Хувьсгалын 53 жилийн ойн үндэсний баярыг тохиолдуулан халуун байр хүргэж Монгол Ардын Хувьсгалт Намныхаа XVI их хурлаар батлагдсан намын программын зорилтыг биелүүлэх үйлдвэрлэх амжилт олохыг Төв аймгийн бүх хөдөлмөрчдөд хүснэ ерөөжээ.



Баянчоогын САА-н тракторч комбайнч Ардын Их Хурлын депутат Д.Очир, Монголморьт сумын Улаан баатар нэгдлийн салбарын БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат А.Ичинхорлоо нар таван жилийн төлөвлөгөөг 2 жил 3 сараас 2 жил 5 сарын өмнө биелүүлэв.



Ойн аж ахуйн мужаан Н.Мижид таван жилийн төлөвлөгөөг 2 жил гаруй өмнө биелүүлэв. Баяндэлгэр сумын кино механикч аймгийн аварга Д.Доржгочоо 3 жил 9 сарын өмнө таван жилийн төлөвлөгөөг биелүүлжээ.

БАЯР НААДАМДАА БАРЬСАН БЭЛЭГ

Аймгийн яруу алдарт ажилчин анги, бүтээлч хөдөлмөрчид МАХН-ын III их хурал болон БНМАУ-ыг тунхагласны 50 жил, Ардын хувьсгалын 53 жилийн түүхт ойг хөдөлмөрийн өндөр амжилтаар угтах уриан дор бүх ард түмний социалист уралдааныг өрнүүлэн ажиллав.

1974 оны социалист уралдаанд нийт ажиллагсдын 98,4 хувь нь үүрэг амлалт авсны дээр угтвар төлөвлөгөөтэй байгууллага 6, уралдааны гэрээтэй цех, тасаг, үйлдвэр, албан газар 28, ажилчинд 682, хувиар бүтээлч төлөвлөгөөтэй инженер техникийн ажилтан 85 байна.

БНМАУ-ын хөдөлмөрийн баатар А.Орногвийн туршлагаар 3 бригад нэхмэлчин Гүнжилал, Ц.Хорлоо нарын туршлагаар 3000 гаруй хүн 1—5 жилийн хувийн тооцоотой үүрэг авснаа амжилттай биелүүлж байгаа ба одоо аймгийн хэмжээгээр V таван жилийн төлөвлөгөөг

биелүүлсэн гавшгайчид 160 гаруй болоод байна.

Энэ онд таван жилийн төлөвлөгөөг биелүүлэхээр 7 байгууллага, 162 хүн өндөр үүрэг авсны гадна бүх ард түмний социалист уралдаанд шалгаргачдын чуулга уулзалтаас 6 өдрийн ажлыг 5 өдөрт хийхээр гаргасан уриалгыг хүлээн аваад тус аймгийн хөдөлмөрчид урьд авсан үүрэг дээрээ 921,1 мянган төгрөгийн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн төлөвлөгөөт алдагдлыг 120,0 мянган төгрөгөөр багасгаж 385,1 мянган төгрөгийн нэмэгдэл ашиг олох, байгалийн баялаг, дотоод нөөц бололцоог ашиглах замаар 119,6 мянган төгрөгийн хуримтлал буй болгох, том малын зүй бусын хорогдлыг 32,4 хувиар багасгаж, мал өсгөх хөдөлшгүй төлөвлөгөөг 24,6 мянган малаар давуулах үүрэг авав.

1974 оны эхний хагас жилийн социалист уралдааны дүнгээс үзвэл: Айм-

гийн хэмжээний төлөх эх малын 92,7 хувь нь төлөж гарсан төлийн 97,6 хувь буюу 538,8 мянган төл бойжиж байгааг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 21,9 хувь буюу 100,3 мянгаар илүү байна.

Малын зүй бусын хорогдол оны эхэнд байсан малын 1,5 хувь, өнгөрсөн оны мөн үеэс 39,4 хувь буюу 14,1 мянган толгой малаар бага байна.

Үйлдвэр аж ахуйн газрууд хагас жилийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөг 114,3 хувиар биелүүлж 867,3 мянган төгрөгийн бүтээгдэхүүн илүү үйлдвэрлэсэн нь уралдаанд авсан үүргээ 1,4—9,5 хувиар давуулав.

Манай тариаланчид үр тариа тариалах төлөвлөгөөг 103,0 хувь биелүүлэв. Худалдаа бэлтгэлийн 43 нэр төрлийн зүйлээс 23 нэр төрлийн төлөвлөгөөг 100 ба дээш хувиар биелүүлэв.

ПОЧИРВАТ

ӨВС ХАДЛАН — ОН ТАРГА

ХАДЛАНГ ШИМ ТЭЖЭЭЛТЭЙ ҮЕД НЬ БЭЛТГЭНЭ

Тус сонины редакци „Өвс хадлан—он тарга“ гэсэн ээлжит булалтаа энэ дугаараас эхлэн нээж байна. Иймд малаа арвин их хадлан тэжээл бэлтгэх ажилд гарч буй ололт туршлагыг бататгаж дэлгэрүүлэх, дутагдлыг шүүмжлэн илрүүлж засахтай холбогдсон мэдээ материалыг орлогоор ирүүлэхийг уншигч, бичигч идэвхтэн та бүхэнд хүсч байна.

1974 оны өвс хадлан бэлтгэх кампанит ажил эхэллээ. Баян-өнжүүл сум ноднин хадланд эхлэн орохдоо хэсэг хугацаанд жигдрэхгүй удааширч байсан ба үүнээс шалтгаалан төлөвлөгөө биелүүлэх хугацааг хожимдуулж байсан билээ.

Энэ байдлаас дүгнэлт хийж энэ жилийн хадланд хэрхэн бэлтгэснийг тус сум-нэгдлийн дарга ДОР-ЖООС манай сурвалжлагч Л. ГУНГААБУУГИЙН тавьсан асуултанд хариулсныг дор нийтлэв.

АСУУЛТ: Энэ жилийн хадлангийнхаа бэлтгэж-лэн талаар ярьж өгнө үү?

ХАРУУЛТ: Бид 1973 онд хадлан бэлтгэх ажилд гарч байсан дутагдалд дүгнэлт хийж хадлангийн бэлтгэл ажлын талаар нэгдлийн зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцлээ.

Хадлангийн техник запас хэрэгслийг 5 сард татаж авсан. Энэ жил манай сум-нэгдэл 3000 тонн өвс бэлтгэх төлөвлөгөөг 9 сарын 1 гэхэд биелүүлэх зорилго тавьж үүний тулд мал аж ахуйн 3 бригад, нэг механикжсан салааны хүчээр трактор 16, трактор тармуур, хадлуур тус бүр 4, пресс 3, морин машин 12, тармуур 6-тай, 70-аад хүнтэйгээр „Тоосго-

тын даваа”-нд гарч ажиллана. Гар хадлуурын нэг бригад гаргана.

Мөн хүн бүрээр 50-аас доошгүй кг витаминт тэжээл бэлтгүүлэх даалгавар гардуулж өгөөд байна. Хадлангийн үеэр ажиллах тогтооч, тоо бүртгэгч нарыг бүрэн томилж бэлэн болголоо.

Хадлангийн явцад эд-рэл саатал их гардаг морин машин, тармуур зэрэг техникт засвар хийв.

Энэ жил бид суурнар хадланг нь бэлтгүүлэх зохион байгуулалт хийсний дээр хадланчдын уралдааны болзол гаргаж 100 давсан хувьтанг шалгаруулж шагнаж байхаас гадна бригадын дарга, тракторч нарыг улсын амралтанд амруулах уралдааны болзол гаргаж хадланчдад тайлбарлан таниулах ажил хийлээ.

Энэ жил хадаж авсан өвсөө хашиж хамгаалаад байнгын ажиллуулах сахиулууд томилж тэнд нь гэрээр нь буулгаж ажиллуулахаар эхэлж байна.

АСУУЛТ: Ноднин танай сумын хадлангийн ажилд гарсан ололт, дэлгэрүүлүүштэй туршлага, цаашид засвал зохих ямар дутагдал байсан бэ?

ХАРУУЛТ: Манай сум

нэгдэл бүх ард түмний социалист уралдааны жил 1973 онд хадланчдаар тодорхой үүрэг амлалт аваж хуулж ажилласны үр дүнд хадлангийн төлөвлөгөөг 9 дүгээр сарын 15-ны байдлаар 105,0 хувиар биелүүлсэн. Хадланчдын уралдааныг 7, 10 хоног тутам дүгнэж, түрүүлсэн бригад, тасаг, хүмүүст цалинт дарцаг шилжүүлж байсан нь хүмүүсийн идэвхийг өндөржүүлсэн ажил болсон юм.

Өнгөрсөн онд манай нийт хадланчид жигд сайн ажилласны дотор „Тариа” бригадын тракторч Б. Ядамсүрэн, Д.Цэрэнчимэд нар сумын аварга хадланч болсон юм.

1973 онд өөрийн сумын нутагт хадлангийн 3 бригад, Лүн сумын нутагт 1 бригад тус тус гаргаж ажиллуулсан.

Тэд цөм төлөвлөгөөгөө хугацаанд нь амжилттай биелүүлсэн юм.

Манай сум—нэгдэл хадлан өвсөө тээвэрлэж мал аж ахуйн бригадуудын төвд татаж, манаач сахиултай болгон өвлийн болон төлийн бэлтгэлийн үеэр суурнуудад хуваарилж өгсөн нь зүйтэй арга хэмжээ болов.

Харин хадланд эхлээд орохдоо хүмүүс жигд гарахгүй удааширч дутагдал байсан ба төлөвлөгөөг ерөнхийд нь оройтуулж биелүүлсэн. Өвс ногооны шим тэжээл муудсан хойно хадлан авах нь ихээхэн хортой юм. Иймд бидний гол зорилт бол энэ жил хамгийн богино хугацаанд арвин их ургац хураах явдал мөн.

Энэ жил хур бороо ургацтай байгаа ч гэсэн багатай сайтай газрыг сонгож олоод хадлангийн нэг бригадаа Туулын хөвөө дагуух „Тоосготын даваа” гэдэг газар гаргах зохион байгуулалт хийгээд байна.

Сум, хот, хороодын 1974 оны эхний хагас жилийн социалист уралдааныг цуваагаар байр эзлүүлсэн дүн

№	Сумдын нэр	1973 оны эхний хагас жил	1974 оны эхний хагас жил
1.	Угтаал	1	1
2.	Баян-өнжүүл	4	2
3.	Баянцагаан	23	3
4.	Батсүмбэр	8	4
5.	Сэргэлэн	18	5
6.	Баянзүрх	21	6
7.	Баяндэлгэр	7	7
8.	Дэлгэрхаан	20	8
9.	Эрдэнэсант	13	9
10.	Баян	22	10
11.	Борнуур	5	11
12.	Жаргалант	2	12
13.	Баянцогт	3	13
14.	Мөнгөнморьт	15	14
15.	Баянжаргалан	10	15
16.	Өндөрширээт	12	16
17.	Баянчандмань	25	17
18.	Алтанбулаг	9	18
19.	Лүн	11	19
20.	Бүрэн	19	20
21.	Заамар	6	21
22.	Эрдэнэ	14	22
23.	Зуунмод	25	23

Аймгийн үйлдвэр аж ахуйн газруудын 1974 оны эхний хагас жилийн ажлын цуваагаар байр эзлүүлсэн дүн

№	Байгууллагын нэр	1973 оны эхний хагас жил	1974 оны эхний хагас жил
1.	СХ-ийн Зам ашиглалтын анги	1	1
2.	Хүнсний үйлдвэр	4	2
3.	XIII авто бааз	8	3
4.	Харилцаа холбоо	9	4
5.	СХ-ийн Сонины үйлдвэр	3	5
6.	Ойн аж ахуй	2	6
7.	Усны аж ахуйг удирдах газар	5	7
8.	НААУ-ний газар	7	8
9.	Барилга угсралтын контор	11	9
10.	Эмийн сангуудыг удирдах газар	6	10
11.	Угтаалын ТУ	=	11
12.	Баянцогтын тэжээлийн үйлдвэр	=	12
13.	Архустын ТАА	=	13
14.	Эрдэнэсантын ТАА	=	14
15.	Нэгдэл дундын үйлдвэр	=	15
1.	Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа, УГ-ийн зөвлөл		

НАМЫН УДИРДЛАГЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭЛ

Шинжлэх ухааны үндэстэй удирдлага гэдэг бол нийгмийн бүх системийг үр ашигтайгаар ажиллуулахын тулд социалист нийгэмд байдаг зүй тогтоол дэвшилтэт хандлагыг танин мэдсэний үндсэн дээр хүмүүс болон нийгмийн системд ухамсартай чиглэсэн зорилготой нөлөөлөхийг хэлдэг.

Одоо үед намын удирдлагын шинжлэх ухааны үндэслэл улам хурц тавигдах боллоо. Үүний шалтгаан нь: Социалист байгууллагуудын хэмжээ далайц өргөжин гүнзгийрч дараа дараагийн зорилт улам нарийн төвөгтэй болж байна.

Тухайлбал: Манай оронд социализмын материал техникийн баазыг байгуулах социалист үйлдвэрлэлийн харилцааг боловсронгуй болгох, социализмын үеийн шинэ хүнийг хүмүү-

жүүлэх үндсэн гурван том зорилтыг нэгдэлтэйгээр нэгдгээр эхлээд хийгдэж байна. Ойрын ирээдүйд социалист орнуудыг хөгжлөөр гүйцэн нэгэн зэрэг коммунист нийгэмд шилжин орох зорилтыг нам тавьж байгаа билээ.

Шинжлэх ухаан техникийн хувьсгал өрнөж шинжлэх ухаан шууд үйлдвэрлэх хүчин болон хувирч байна. Энэ бүхэн нь намын удирдлагын шинжлэх ухааны үндэслэлийг байнга дээшлүүлж байгааг шаардаж байна. Орчин үед амьдрал шинэ шилнэ асуудлуудыг дэвшүүлэн тавьж аль дэвшилттэй сайн аргыг шинжлэх ухааны үндэстэйгээр боловсруулан тавьж хэрэгжүүлэх нь чухал боллоо.

Намын удирдлагын арга барилыг боловсронгуй болгох зорилтыг удирдах ажилтнууд өндөр мэдлэг

мэргэжилтэй байж гэмээ нэ биелүүлж чадна.

Удирдах хүн удирдлагын шинжлэх ухааны үндсийг эзэмшсэнээр хүмүүсийн сэтгэх зүй, нийгэмд хамт олон ба хувь хүний эзлэх байр тэдний харилцаа, хүсэл эрмэлзэл зэргийг таньж мэдсэний үндсэн дээр хүн тус бүрийг сургаж хүмүүжүүлэх зоригжуулан идэвхжүүлэх аргаа зөв сонгож хэрэгжүүлэх ёстой.

Удирдах ажилтан бүр ямарч зав чөлөөгүй байлаа гэсэн боловсрол мэргэжлээ дээшлүүлэх хэтийн төлөвлөгөөтэйгээр өдөр бүр цаг гарган ажиллавал зохино.

Удирдлагын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулахад төрөл бүрийн мэдээллийг шуурхай үнэн зөв боловсронгуй болгох явдал чухал юм.

Үүний тулд нийгмийн

тодорхой судалгаа явуулж түүндээ үндэслэн нийгмийн амьдралын аливаа ажил хэргийг шинжлэх ухааны үүднээс зөв удирдах практик арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэхэд туслах явдал юм.

Судалгаа хийхэд тоо бүртгэлийн мэдээ, албан ёсны баримт бичигт шинжилгээ хийх, анкет аман ба бичгийн асуултад хариу авах, эрдэм шинжилгээний онол практикийн хурал зохиох зэрэг олон арга байна.

Харин авсан анкет судалгаа материалд нарийн дүн шинжилгээ хийж авах арга хэмжээг төлөвлөн явуулах ёстой юм.

Нийгмийн тодорхой судалгааны үндсэн дээр авч явуулж байгаа арга хэмжээ, гаргаж байгаа шийдвэр хүмүүсийн ажил амьд-

рал санаа бодолд хир нийцэж тэд юуг хүсч санаж бодож байгааг танин мэдэж удирдлагыг шинжлэх ухааны үндэстэй явуулахад туслана.

Намын ажлын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах өөр нэг арга бол ажлыг тодорхой баримжаа чиг, зорилго нарийн дараалалтай явуулах явдал юм. Намын тэргүүний байгууллагууд хөдөлмөрийн хамт олныг хөгжүүлэх 5—10 жилийн төлөвлөгөөтэйгээр ажиллаж амжилтанд хүрч байна.

ЗХУ-ын туршлагаар Баянхонгор, Төвийн эрчим хүчний системийн намын байгууллага зэрэг нилээд газарт хамт олныг нийгэм соёлын талаар хөгжүүлэх цогцос арга хэмжээний хэтийн төлөвлөгөө зохион ажиллаж байгаа дэвшилтэд аргыг нэвтрүүлэх нь удирдлагыг төгөлдөржүүлэх чухал зүйл юм.

М. САМДАН

Манай ард түмний оюун билгийн охь дээж болсон ардын аман зохиол арвин баялаг өв уламжлалтай билээ.

Энэ нь зүйр цэцэн үг, оньсого таавар, ертөнцийн гурав, ерөөл магтаал, ардын дуу, домог хууч, үлгэр тууль гэх мэт хэд хэдэн төрөлд хуваагдана.

Жишээ нь:
Арчилбал эдэнд тустай
Арвилбал эзэнд тустай
гэх буюу:

Дуслыг хураавал далай болно

Дуулсныг хураавал эрдэм болно

гэх зэргээр аливаа юмыг арвилан хэмнэх ба арчилан хамгаалахын чухлыг ардын цэцэн үгэнд ийнхүү өгүүлсэн бол шаазгай шувууны тухай оньсогонд:

Тээг тээг явдалтай
Тэхэн сайран гуталтай
Алаг булган дахтай
Алтан уурга чирээстэй
гэж түүний гадаад шинж төрхийг уран яруу, хүний ухаан санаанд шууд буухаар үнэхээр ойлгомжтой тод дүрсэлсэн байдаг.

Тэгэхдээ ерийн нэг хүүрнэн өгүүлсэн бус харин мөр бүр гурван үгтэй бөгөөд эхний хоёр мөрийг "т", үсгээр, эцсийн хоёр мөрийг "а", үсгээр тус тус толгой холбосноос гадна, бас эцсийн

дөрвөн мөрийг хамтрахын тийн ялгалын "тай", "тэй", нөхцөлөөр сүүл холбосон нь шүлгийн хувьд улам ч утга төгөлдөр урлагтай болжээ.

Тэрлэн монгол ардын аман зохиолын бусад төрлийн тухайд энэ мэтээр тайлбарлан өгүүлж болох юм. Ардын зохиол нь байнга нэгэн хэвийн байдалд бус, тухайн үеийн үнэн бодит амьдралыг ямагт өөртөө тусган илэрхийлж, шинэ шинэ зүйлээр арвижин хөгжиж үүний нэр төрөл утга агуулга нь нэгэн адил өргөжин хөгжиж байдаг

АРДЫН АМАН ЗОХИОЛ

оршино. Тухайлбал:

Ах дүү гурав
Ар өөрөөр нутагтай
Арзанал улаан өнгөтэй
Алс хэтийн зорилготой
Аймшиггүй зоригтны
тангарагтай
Атгасан гар нь зангидаатай

гэж пионерийн улаан бүчийг оньсоголон өгүүлжээ.

Энэ бол урьд өмнө байгаагүй шинэ сонин зүйл юм. Өөрөөр хэлбэл манай оронд пионерийн байгууллага зөвхөн ардын хувсгалын дараа буй болсон

тул пионерийн тухай эл оньсого нь монголын ард түмний шинэ амьдралын нэгэн тод тусгал болж байгаа нь илэрхий юм.

"Ертөнцийн гурван их,"
"Гурван ариун," гэдэг зүйлүүдэл:

Халамжит намын ивээл

Хамтарсан ажлын бүтээл их

Хайрт эхийн энэрэл их

Эх хүний сэтгэл ариун

Эх орончийн зүтгэл ариун

Энх тайвны үйлс ариун

гэх мэтээр намын ач ивээл, энх тайван, хамтын хөдөлмөрийн давуутайг өгүүлжээ.

Энэ нь манай орчин үеийн аман зохиол хуучин өв уламжлалынхаа дэвшилт дээр шинэ шинэ сэдэв агуулгаар улам баяжин хөгжиж байгаагийн бас нэг тодорхой гэрч юм.

Үүнээс үзэхэд монгол ардын аман зохиолын яруу сайхан үг өгүүлдэмж гүн гүнзгий утга санаа нь манай хөдөлмөрчдийн оюун мэдлэгийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болохыг өгүүлэх юун ажээ.

Иймд өргөн олон уншигчдад зориулан монгол ардын аман яруу найргийн зарим нэг төрлийг нийтлэв.

У. ЗАГДСҮРЭН

ДЭЛГЭР ЦАГИЙН МАГТААЛ

Зээ!
Зуны цагийн дэлхий
Зүйтэй сайхан байхад
Цэцэрлэгийн ой дунд
Цэцэг жимс ургана
Олон давхар үүл нь
Огторгуйдаа тулалцаад
Үзэсгэлэнт солонго нь
Өнгө нийлэн татна
Зүс хур ороод
Зүлэг ногоо сэргээд
Говь газар манараад
Голын зүлэг сэргэнэ
Хөдөө газар хөхрөөд
Хөхөө шувуу донгодно
Ой мод дэлгэрээд
Олон цэцэг найтана
Тунгалаг нуур мэлмийгээд
Товруун цэцэг ганхалзана
Яруу дуутай шувуу нь

Уянгатайгаар донгодоод
Үр жимс төгсгөсөн
Энэ цагийн зун нь
Үргэлжид дэлгэрээд
Өнө бат байтугай
Хөгшин залуу бид нар
Хүүрнэн найрлаж суухад
Ерөөдөр учирч
Үелж найралай
Найрлан цэцэгн суухад
Настан сэтгэл сэргээд
Сайхан амраг сэтгэл минь
Салшгүй байдаг л
Манай энэ бие
Маш мөнх болоосой
Орчлонгийн ёсонд
Огт мөнх үгүй л
Арван зүгийн амьтад
Асар сайтар баясаж
Ариун сайхан орондоо
Аяа найртай жаргай!

ХАНХАР ТАШАА ЗЭЭРД

Зээ!
Манлай түргэн гишигдэлт
Манай бага бор л
Мартал үгүй санагдагч
Манай бага авгай
Мөсөн уулын шилд
Мөндөр хур орно
Мөрөөсөгч сэтгэл минь
Ээж дээрээ билээ л
Өндөр дээр гарахад
Хангайн бараа илхэн
Өндөр их Аргалант
Туяарч харагдана
Өргөн их Туул минь
Хүрэнтэж харагдана
Үерлэхийн хирд
Тойрмын тал халина


Үдийн их халуунд
Сүүдэр минь билээ л
Үеийн олон цуглахад
Түшиг минь билээ л
Агсагсанхан саадаг чинь
Арын харгай адил
Ах дүү улсыг доромжлох
янзтай
Доромжловч яахав
Цэгээн нууранд зуссан
Цэвэрхэн шарга морь л
Цэвэрлэж есгөсөн
Аав ээж хоёр л
Ханхар ташаа зээрдээр
Хангайн давааг давьаа
Далай их буянаар
Даяар хамт жаргай!

НААДМЫН ДЭВЖЭЭНД ТӨРСӨН БОДОЛ

Хүний баяр сэтгэлдээн үл багтаад
Хүй энэ талбарт алаглаж байна уу гэмээр
Нарны халуун туяанд өмсөж зүүсэн
нь солонгорох
Наадмын ханагар дэвжээг морьтны
хөл дарж байна
Үүлэн цэнхэр далбаандаа багтаж
ядан байх
Үлэмж чадлын цээжийг ханхалзуулж,
Үнэтэй наамлын түрийг гадагш түрсэн
Үегүй мэт хөших хөлөөр доргитол
гишиглэн
Гагцаар, энэ наадмын чимэг мэт аврага
Ганхасхийн зогсох засуулаа тойрон
дэвлээ
Дуу айргаар дүүрэн цэнхэр асрын
дээгүүр
Дуулгатай баатрынх мэт дэвсэн га-
раа гялалзуулж
Олны өмнө намилзах соёмбот тугийн
дэргэд
Одоохон тойрохын учир сүжирхэх
адил зогслоо

Хангай ийм эрийн тэнцэх учраа
Хан Алтайн чинээ байгаа даа гэтэл
Анх өмссөн зодог хааш хаашаа элбэгдэх
Атигар нэгэн хүү гуяа алгадан гарав
Зузаан ултай наамлаа дааж ядах мэт
Зуу зуугаар цугларсан олны өхөөрөлд
дарагдах мэт
Зугуухнаа очих хүүгийн хөл дор
Зуны сайхан тал алаг цэцгээ дэвсэн
байна
Зөрж барилцсан гар гялсхийх агшинд
Зөөлхөн унаасай гэж хүүг би өрөвдөв
«Зөгнөд» гэвч буруудаж бяцхан хүү
давчихад
Зөнгөөрөө ширүүсэх бороо шиг алга
ташилт нижигнэв
Саруул ухаан чин зориг байвал
Сав орчлонд мөхөсдөхгүй гэж тэгээд
би бодлоо
Оюун ухаан л бүгдийг шийдэх
Орчин үе гэж сэтгэлдээ дуу алдлаа

Д. ЦОДОЛ



Уяа сойлого нь таарсан агтны манлай аргамаг хурдан холгууд
Л.ДАМДИНДОРЖ-ийн авсан судалбар гэрэл зураг.

ЭРХЭМ ЖАРГАЛАНТ НУТАГ

Зээ! Өөдөлж гарав
Өргөн сайхан Хэрлэн
Өсөг юугаан сацав
Жаргалант Хэрлэн зээ!
Тийм сайхан нутаг минь
Одоо ямар болов
Жаргалант Хэрлэн зээ!
Зээ! Уралдаж явав л
Урт сайхан Хэрлэн
Унага-даагаа барив л
Зүлэг сайт Хэрлэн
Тийм сайхан нутаг минь
Одоо ямар болов
Жаргалант Хэрлэн зээ!
Зээ! Хатирч явав л
Халгаа үгүй Хэрлэн
Харван намнан явав л

Гөрөөс сайт Хэрлэн
Тийм сайхан нутаг
Одоо ямар болов
Жаргалант Хэрлэн зээ!
Зээ! Дэр нь үгүй хэвтлээ
Дэгнүүл сайт Хэрлэн
Дэвсгэр үгүй хэвтлээ
Зүлэг сайт Хэрлэн
Тийм сайхан нутаг минь
Одоо ямар болов
Жаргалант Хэрлэн зээ!
Зээ! Ард нь ургасан
Овор товор хайлс нь
Амин зуураа наадсан
Гучин хоёр шатар минь
Тийм сайхан нутаг минь
Одоо ямар болов
Жаргалант Хэрлэн зээ!
Зээ! Өвөрт нь ургасан
Өвөр цөвөр хайлаас нь
Өөр зуураа наадсан
Гучин хоёр шатар минь
Тийм сайхан нутаг минь
Одоо ямар болов
Жаргалант Хэрлэн зээ!

*Эрхэм Жаргалант нутаг хэмээх Хэрлэн голын тухай энэ магтуу дууг 300 дүү бүхий монгол ардын дууны бичмэл цоморлигоос авав.

ЗҮЙР ЦЭЦЭН ҮГС

Дээлээ шинэд нь
Нэрээ цэвэрт нь
Аавын сургаал алт
Ээжийн сургаал эрдэнэ
Сайн хүнтэй ханилбал сарны гэрэл
Муу хүнтэй ханилбал могойн хор мэт
Буруу хүмүүжсэн хүүхэд
Бухын хүүхдээс хөшүүн
Эдээр биеэ чимэхээр
Эрдмээр биеэ чим

Манай улсын хүн амын тоо 1377,9 мянгад хүрч 60 гаруй хувь нь хөдөөд оршин сууж байна.

Хүүхэд, 16 хүртлэх насны залуус хүн амын 40 гаруй хувийг эзэлж байна. Манай орны хүн ам сүүлийн 55 жилд 2 гаруй дахин өсч ЗХУ-ийн орнуудын дотор хүн амын жилийн өсөлтөөр хамгийн өндөр орон болжээ.

1921 онд МАХНэгнээндээ 150 гишүүнтэй байсан бол одоо 61 мянган гишүүд, орлогч гишүүдтэй юм. 1950—1973 онд улс ардын аж ахуйн хөрөнгө оруулалт 29 дахин, үндэсний орлогын төвшин 1969 оныхоос 160 хувь болж өсөв. Аж үйлдвэрийн үйлдвэрлэл одоог 1950 онтой харьцуулахад 9,5 дахин, машины болон металл боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн 1950 оныхоос 20,5 дахин давжээ. Ард түмний хэрэгцээг барааны бараг

тэн хагасыг эх орондоо үйлдвэрлэж байна.

Улс ардын аж ахуйн үндсэн фонд нийгмийн нийт бүтээгдэхүүн, үндэсний орлого 1973 онд 7 гаруй хувиар, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 8 хувиар тус тус өссөн байна. 1923—1973 онд ЗХУ-ын оролцоотойгоор аж үйлдвэр, ХАА, соёл ахуйн 450 гаруй барилга байгууламж баригдсаны

манай орны аж үйлдвэрийн бүх бүтээгдэхүүний 38 хувийг үйлдвэрлэж байгаагийн дотор түлш эрчим хүчний 90 хувь, нүүрсний 85, угаасан ноос, эсгий, багсармал тэжээлийг зуун хувь үйлдвэрлэж байна.

Тавин жилийн тэртэй манай оронд 100-гаадхан ажилчин байсан бол IV таван жилд техник мэргэжлийн 23 сургуулиар

тэн хагасынх нь жилийн орлого 2 сая төгрөг болж байна. 1973 онд 7,8 сая төл бойжуулж, төлөвлөгөөнөөс 800,0 мянган төл илүү бойжуулжээ. 1973 онд манай улс түүхэндээ үр тарианы хамгийн арвин их ургац 32 сая пүүр тариа хураав.

Мөн онд 800 мянган тонн өвс бэлтгэсэн нь 1972 оныхоос бараг 17 хувь их өвс юм.

хүн буюу дөрвөн хүний нэг нь дээд дунд сургуульд суралцаж 50 гаруй мянган хүн дээд дунд боловсрол эзэмшиж, 16,0 мянга орчим охид хөвгүүд ЗХУ-д суралцаж байна. Ардын эрүүлийг хамгаалах үйлст амжилт олж 1973 онд 67 болон, их бага эмчийн 1060 салбар, поликлиник диспансер, амбулатор, түргэн тусламжийн станцууд олон арваараа ажиллаж байна.

Одоо манай улсад 110 мянган хүлээн авагч, радиогийн 2 станци ажиллаж байгаагийн дээр Улаанбаатар, Дархан, Зуунмод хот болон тэдний дүүрэгт оршин суугчид үндэсний болон орбитын хөтөлбөрөөр телевизийн нэвтрүүлгийг сонирхдог болсноор манай оронд 20,0 гаруй мянган телевизийн дэлгэц ажиллаж байна.

Н. ХАНДСҮРЭН

ЭХ ОРНЫ ХӨГЖИЛ ЦЭЦЭГЛЭЛТ

(ТОО БАРИМТ)

дотор Дархан, Чойбалсан, Улаанбаатарын ТЭЦ эрчим хүчний нэгдсэн систем, Налайхынх уурхай, Шарын гол, Адуунчулуны ил нүүрсний уурхай зэрэг уул уурхайн олзворлох үйлдвэрийн газрууд зүй ёсоор ордог.

ЗХУ-ын барьж байгуулж өгсөн үйлдвэрүүд

20,0 мянган ажилчид бэлтгэв. Чойбалсан, Арвайхээр хотод залуу ажилчид бэлтгэх иж бүрэн барилга байгууламж баригдав. Энэ таван жилд 25,0 мянган охид хөвгүүд мэргэжил эзэмшиж ажилчин болно. Манай улс ХАА-н 268 нэгдэл, 32 САА-тай нүүрс ХАА-н нэгдлийн

ЗХУ-ын тусламжтайгаар багсармал тэжээлийн үйлдвэрүүд байгуулагдаж 20 завод цех ашиглалтад орсоны гадна тэд 1974 онд 170,0 мянган тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэв. 1921 онд ерөнхий боловсролын ганц сургууль байгуулагдаж байсан бол 1973 онд 307,9 мянган

Өрлөгчдийн сонгон шалгаруулах уралдаан

Бүрэн сумын төвд баригдаж байгаа 320 хүүхэд хичээллэх дунд сургуулийн барилга дээр барилгачид ган нийвийгээ гялалзуулж, цэргийн өмнөх насны идэрчүүд зуурмаг бэлтгэж, шинэ мэргэжилд зорьсон барилгын техник мэргэжлийн сургуулийн сурагчид, мөн нэмэгдэл хүч болон туслаж байгаа сумын төвийн хөдөлмөрчид 120 гаруй хүн нэгэн хүч болон амсхийх завгүй ажиллаж байлаа. Энэ өрнүүн хөдөлмөрийн зэрэгцээгээр аймгийн ХТАЗ-ий зөвлөд, аймгийн ХАА-н барилгажуулалтын комиссоос зохион явуулсан Төв, Дундговь аймгийн барилгын өрлөгийн мэргэжил сонгон шалгаруулах 4 өдрийн өндөр бүтээлийн уралдаан 1974 оны 7 дугаар сарын 2-ны өдрөөс 6-ны өдрийг хүртэл явагдаж ажлын арга техник, хүч чадалаа со-

рилцов. Ижил мэргэжлийн энэ уралдаанд Төв аймгийн БУК-ын өрлөгчин Д. Намсрай, Н. Пүрэвжав, Дундговь аймгийн өрлөгчин В. Бямба нар өдөр тутмын нормоо 1—3 дахинаар давуулж биелүүлэн уралдааны үзүүр түрүүг булаачалдан байв.

Эсийн дүнг уралдааны комиссоос гаргахад өндөр бүтээлийн уралдааны хугацаанд бүх өрлөгчид дунд зэргийн гоёлтой 64 см зузаантай цагаан тоосгон өнгөлгөөтэй гадна ханын өрлөг 221,3 кубметрийг хийж төлөвлөгөөг 273,1 хувиар, 38 см зузаантай дотор тоосгон ханын өрлөг 36,6 кубметр хийж төлөвлөгөөг 466 хувиар биелүүлэв. Төв аймгийн 5 удаагийн аварга барилгачин Д. Намсрай ахлагчтай 5 өрлөгчид гадна ханын өрлөг 112,1, дотор ханын өрлөг 13,7 кубметрийг, Дундговь аймгийн барилга трестийн аварга В. Бямба ахлагчтай 7 өрлөгчид гадна ханын өрлөг 99,1 кубметрийг, дотор ханын өрлөг 11,5 кубметрийг Улаанбаатарын барилгын ТМС-ийн Гансүх ахлагчтай сурагчид 10,7 кубметрийн өрлөг хийжээ.

Уралдаан дүгнэхэд 1 дүгээр байрт Төв аймгийн БУК-ын өрлөгчин Д. Намсрай, Н. Пүрэвжав нар, 2 дугаар байрт Дундговь аймгийн барилга трестийн өрлөгчин В. Бямба, Төв аймгийн БУК-ын өрлөгчин Р. Равдандорж, Д. Ухнаа, Ц. Намсрай, 3 дугаар байрт Дундговь аймгийн барилга трестийн өрлөгчин Хишигтогтох, Ж. Баатар, Цогзол Батаа, Балжинням нар оров.

Д. БАДАРЧ

Ахмад малчдын залуу халаа

Хүн болох багаасаа хүлэг болох унаганаасаа гэж эцэг өвгөдийн минь цэцлэж хэлсэн сайхан үг бий. Дуламсүрэнг бүр бага байхад Намсрай гуайнх аминь цөөн малын ашиг шинээр амьдардаг айл байлаа. Хашаа хорооны нөмөр бараадан няхишигтэй өдөржин тоглож өнжих балчир охиноо эх нь миний охин ямаачин болох юм байлгүйгээ гэж зөгнөн боддог байж.

Охин өсч өндийн ухааны цар нэмэх тутам малд ялангуяа ишгэнд улам их хайртай байлаа. Ишгэндээ чихэр боов өгч хаа ч явсан дагуулж явдаг байснаас тэд «эрх танхи» амьтад болж, ээж нь малд муу зан сургалаа гэж балчир охиноо хааяа эзмэлдэг болов.

Гэвч охины хэдэн «эрх танхи» ямаад өөр өөрсдийн нэрийг тунч андахгүй. Бас эзнийхээ дууг бусдын дуунаас ялгаж танина: Эзэнээ зандах үед гэмшингүй байдалтайгаар сүүлээ хөдөлгөн гомдолтойгоор майлана.

Ингэж балчир охин Дуламсүрэн багаасаа мал маллахын эрдэм ухаанд суралцжээ. Хожим тэр

Алтанбулагийн 8 жилийн дунд сургуулийг төгсгөж, МХЗЭ-ийн илгээлт өвөрлөн ХАА-д гарахаар саналаа өгчээ.

Дуламсүрэнг МХЗЭ-ийн илгээлт өвөрлөн гэртээ ирэхэд нь бүр багынхаа ишгэнд хайртайгүй нь мэдэх хашир эцэг нь 97 ямаа авч охиноо туршихаар шийдэв.

Эцэг эх хоёр нь охиноо бие даан юу хийж чадахыг нь үзэх гэж тэр зун гүү авч саажээ.

Дуламсүрэн зуны хэдэн

ЯМААЧИН

(ТЭМДЭГЛЭЛ)

сар халуун наранд шарагдан байж, саалийнхаа ажлыг дуусгахад мал нь ч эзэндээ дасч, эзэн нь ч малдаа дасч аль алиныхаа ааш занг андахгүй болж эхлэв.

Мал бүхнээс ямаа хамгийн эртэч амьтан, хэдэн ямаа нь өөрөөс нь заавал түрүүлж босно.

Өөрөө ч эрт босдог болов. Үнэндээ ямаа эрхлэх дуртай амьтан ажээ. Тэд эзэнээ хармагц урал-

дан гүйж ирээд зарим нь ар өврөөс нь цоройлж, зарим нь шөргөнө.

Энэ бүхэн охины сэтгэлд гойд их талалдаг байлаа. Ямаанууд өөрт нь дасч, өөрөө одоо л нэг малчин хүн болж байгаа мэт санагдана.

Хэдэн ямаатайгаа хамт байхад цаг хугацаа өнгөрөхийг ч мэддэггүй ажээ.

Нэг л мэдэхнээсүүцнэ амьтан зугаатай зургаан сар хайруу өвлийн хатуу сарыг мэнд сайн давсан байлаа. Нэгэн жил ийнхүү өнгөрөхөд ажилчид хөдөлмөрөөрөө аварга саальчин гэдэг алдар нэр нэгдэл ч хамт олноосоо авав.

Илгээлтийн эзэн Дуламсүрэн энэ жил хариуцан маллаж байгаа 120 эм ямаанаас 126 ишигт бойжуулж, ноолуурынхаа төлөвлөгөөг 101,2 хувиар биелүүлж 91 хувийг нь 1 дүгээр зэрэгт тушаажээ.

Бас энэ жил ямаа бүрээс 17 литр сүү сааж өөрийн хоёр найзын хамт ямаан суурь байгуулж, хариуцсан сууриа сумын тэргүүний суурь болгох зорилт тавинд ажиллаж байна.

Д. РЭНЦЭНДОРЖ



ЗУРАГ ДЭЭР: Төв аймгийн өрлөгчин Д. Ухнаа



Батсүмбэрийн САА-н саальчин, илгээлтийн эзэн С.Эрдэнэцэцэг тус САА-н саалийн 1 дүгээр бригадад хуваарилгдан Авирмэд баатрын туршлагаар ажилласан анхны жил-1972 онд 52000 литр сүү саахаас 53000 литр, 1973 онд 102000 литр сүү саахаас 102176 литр сүү сааж төл

болоц бусад үйлдвэрлэлийн даалгавраа 100 хувь биелүүллээ.

Түүний амжилтыг үнэлэж МХЗЭ-ийн байгууллага, коммунизмын ууган орон—ЗХУ-д 30 хоног жуулчлууллаа.

Нам, эвлэлийнхээ энэ их итгэл найдвар, хайр ивээл, өндөр шагналын хариуд ажлын өндөр амжилтаар бэлэг барьж, 1974 онд нэг ч малын хорго-

долгүй ажиллаж төл, сумын төлөвлөгөөг 100—101 хувиар биелүүлэх зорилт тавин ажиллаж байна гэж хөдөлмөрийн баатар А.Авирмэдийн шавь, саальчин С.Эрдэнэцэцэг ярьж байна.

Одоо саальчин С.Эрдэнэцэцэг илгээлтийн эздийн чуулга уулзалтын уриалгыг хэрэгжүүлэх ажилд ороод байна.

Р. БАЯРСАЙХАН

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ

ТЭМЭЭЧДИЙН ТУРШЛАГА БҮТЭЭЛ

МАХН—ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл 1973 оны сүүлчээр „Тэмээн сүргийг өсгөх талаар авах зарим арга хэмжээний тухай“ гаргасан тогтоолыг хэрэгжүүлэх талаар Байцаглан сумын намын үүр, А.ДХ-ын гүйцэтгэх захиргаа, нэгдлийн зөвлөлөөс зохиож байгаа зарим ажлын талаар нийтлэв.

Тус сум суулийн хоёр жилд тэмээний аж ахуйгаас 69,0—71,6 мянган төгрөгийн орлого олсны дээр зөвхөн 1973 онд тэмээний ноосны үнийг нэмэгдүүлснээс 26,2 мянган төгрөгийн цэвэр ашиг олсон байна.

Тэмээчдийн дунд эмнэг хангал сургах, ердийн хөсгийн цуваа гаргах, ботгыг гардан бойжуулах зэргээр уралдаан өрнүүлэн ажилласны үр дүнд «Алтат» бригадаас тэмээний ноос ашиглалтын аймгийн аварга Г. Жанцанбалбар, ингэний сүү ашиглалтын аймгийн аварга Д. Дулмаа, эмнэг сургалтын сумын аварга Ж. Бат-эрдэнэ нарын тэргүүний малчид төрөн гарчээ. «Өлзийт» бригад 26 тэмээтэй ердийн хөсгийн цуваа гаргаж 1974 оны эхний 4 сард 1359 тонн-ийн аян хийж, «Алтат», «Гурван түрүү», «Баян-айраг» бригадад төлийн бэлтгэлд зориулан хужир тээвэрлэн 384 машин ачааг буулгажээ.

Тэмээчдийн баярын өдөр болоход сумын төвийн тал бүрээс уналга эдэл-

гээнд сургасан тэмээн цуваанууд ирж аргал, хужир, хөөвөр, ноолуур зэргээ сургууль, нэгдэл, ХБ-ийн ангид буулгаж байв.

Ажлаараа шалгарсан тэмээчдийн баярын хурал болж «Тэмээн сүргийг өсгөж ашиг шимийг нэмэгдүүлэх» гэсэн илтгэл тавьж хэлэлцүүлж хурал дээр тэмээчдийн хийх ажлын удирдамжийг батлан гаргав.

Мөн тэмээчдийн дугуй ширээний ярилцлага болов. Түүнд ингэний сүү ашиглалтын аймгийн аварга Д. Дулмаа, эмнэг сургалтын сумын аварга Бат-эрдэнэ, малчин С. Цэдэвдорж нарын олон малчид оролцлоо. Тэд; тэмээг сургахдаа ботгонд нь уяж, тормонд нь 3-аас доошгүй өдөр сойж хөнгөрүүлж байгаад давхар жоолоо хийж мордох хэрэгтэй. Эмнэг тэмээг унаж эдэлж сургаснаас хойш 2—3 насанд нь буйллана.

Анх тавьсан буурыг морь, тэмээ, явганаар ч гэсэн ширүүн хөөж тууж хаширч, уухайлж болохгүй. Буурыг тавихдаа;

Нүд хури, босоо сахлаг үстэй, монхор хоншоортой, хавирга нь түхэгэр, тавхай нимгэнтэй, дошгивтор тэмээгээр тавих нь зүйтэй.

Ингэний сүү бол хаван, ясны бэртэнг, чийг бамын өвчин, ядаргаанд сайн байдаг. Ингэний жилийн турш сааж болдог. Нэг ингэнээс 140 литр сүү ашиглах боломж манайд бий.

Ботгыг эргүүлэгтэй гадсанд аргамжих хэрэгтэй. Буйлласан тэмээ буруу эргэмтгий учир бурантагийг буруу эрчтэй томлог юм. Бургасан буйл тэмээнд халтай, буйлсан буйл зохимжтой.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд буйл зорох, бурантаг томох, тором сургах дугуйлан байгуулж ахмад туршлагатай малчдаар багшлуулах нь зүйтэй.

Бригад бүрт тэмээн хөсгийн хэсэгтэй болж айл нүүлгэх, аргал хөрвөл, хужир шүү, өвс татах, малын хашааны материал тээвэрлэх зэрэг ойрын тээвэр хийх нь ашигтай.

Эмнэг догшин ингэн тэмээ нь саалинд ороходоо ивэлж өгдөггүй, саальчны ажлыг хүндрүүлдэг учир тэмээг багад нь номхруулан сургах нь чухал гэж ярилцав.

Т. ГАВАА

ИЛГЭЭЛТИЙН ЭЗДИЙГ ХҮЛЭЭН АВАВ

Мөнгөнморьт сумын намын хороо, А.ДХ-ын гүйцэтгэх захиргаа, «Улаанбаатар» нэгдлийн зөвлөл өөрийн сумын дунд сургуулийн 7, 8 дугаар анги төгсч илгээлтээр мал аж ахуй дээр ажиллах сурлагчдыг хөдөлмөрчдийн хурал хийж хүлээн авлаа.

Хуралд сумын нам, захиргаа, олон нийтийн байгууллаагын төлөөлөгчид,

багш, эцэг, эхчүүд 7, 8 дугаар ангийн сурагчид оролцов.

Хурал дээр сумын намын хорооны нарийн бичгийн дарга Жамбал сурагчдад илгээлт гардуулав.

Илгээлтийн эздэд хандаж сумын сайн малчин өвгөн Ширнэн үг хэлэв.

Дараа нь нэгдлийн зөвлөлийн дарга Д. Сундуй

тус сумын үржил фермд үхэрчнээр ажиллах гэж байгаа сурагчдад нэгдлээс гэр, морьт өгч буцаалгүй тусламж үзүүлэхээр шийдвэрлэснийг мэдэгдэж сурагчдад бэлэг дурсгалын зүйл гардуулав. Илгээлтийн эзэн сурагч А. Зоригт нөхдөө төлөөлөн үг хэлж үүрэг авлаа.

Б. ДОРЖСҮРЭН

ЦӨЦГИЙН ТОС ҮЙЛДВЭРЛЭЛТ

Хөдөлмөрчдийн байнга өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээт шаардлагыг хангахад сүү ба сүүн бүтээгдэхүүн цөцгий тос үйлдвэрлэлт онцгой суурийг эзэлдгээрээ улс, ардын аж ахуйн төлөвлөгөөт зорилтын хамгийн чухал хэсгийн нэг байдаг.

Нам, засгаас ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх талаар удаа дараалан чухал арга хэмжээ авч саяхан БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс цөцгий тос цагаан идээ үйлдвэрлэх ажлыг сайжруулах арга хэмжээний тухай гаргасан тогтоолд цөцгий тос үйлдвэрлэх төлөвлөгөөг хугацаанд нь чанар сайтай биелүүлсэн нэгдлийг, жил бүр шалгаруулан шагнаж байхын хамт цөцгий тос үйлдвэрлэх төлөвлөгөөг биелүүлбэл

бэлтгэлийн үнийн 10 хувиар, давуулан биелүүлбэл давуулсан бүтээгдэхүүнд бэлтгэлийн үнийн 50 хувийн урамшлын нэмэгдэл олгож байхаар заасан билээ.

Уг тогтоолыг манай аймгийн бүтээлч хөдөлмөрчид, саальчид, малчид баяртай хүлээн аваад урьд урьдахаас улам ч шаргуу хөдөлмөрлөж байна. 1973 онд цөцгий тос бэлтгэх төлөвлөгөөг Баян-өнжүүл сум биелүүлж аймгийн дүнгээр цөцгий тос үйлдвэрлэх 6 нэгдлээс 59,1 мянган литр сүү хэмнэсэн зэрэг сайн талууд гарсан боловч цөцгий тос үйлдвэрлэх төлөвлөгөөг 15,2 тонн буюу 28,5 хувиар тасалжээ.

Эрдэнэсант сумын «Са-руул-амьдрал» нэгдэл аж ахуйн бэлтгэлийг дутуу хангаж цөцгий тос цо-

хигч гаргаагүйгээс 1000 гаруй литр цөцгийг гашилгаж байлаа.

Эдгээр байдалд дүгнэлт хийж энэ оны цөцгий тосны төлөвлөгөөг хугацаанд нь чанар сайтай биелүүлэх аж ахуй, зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авах нь орон нутгийн нам, улс, ХАА-н байгууллагуудын чухал зорилт байх ёстой.

Сүүний төлөвлөгөө тасарч байгаагийн үндсэн шалтгаан бол олон тооны үнээ сувайрч тугалтай үнээг саалинд бүрэн ханруулаагүй, сүүний гарцын ид нэмэгдэх 7, 8 дугаар саруудад нутаг сольж нүүхгүй нэг газар удаан хугацаагаар олон тооны үнээ бөөгнөрүүлдэг зэрэг дутагдал нөлөөлж байгааг анхаарвал зохино.

Цөцгий тос бэлтгэх ажилд урьдаас сайн бэлтгэж аж ахуйн зүгээс шаардагдах зүйлийн дутууг

сайн хангаж, төлөвлөгөөг хугацаанд нь биелүүлэхэд ажиллах хүч дутагдах саальчингаа төв суурин газар амралт зуслан өргөн айлсалтын хэлбэрээр гаргаж ашигладаг туршлагуудыг хэрэглэн тугалтай үнээ бүрийг саалинд бүрэн оруулах ажлаас эхлэх нь зүйтэй. Цөцгий тос үйлдвэрлэх явцад амины үнээнд сүүний даалгавар өгч аминаас сүүг үнээр нь худалдан авах замаар богино хугацаанд сүү тосны төлөвлөгөөг биелүүлэх нь манай сүү тос үйлдвэрлэлд нийт ХАА-н нэгдэл, САА-нуудын эрхэм чухал зорилт юм. Сүүний тасаг, завод, саальчдын идэвх хөдөлгөөнийг өрнүүлэхийг уралдааныг олон хэлбэрээр өрнүүлэн дүгнэлт тэргүүний сайчуудын туршлагыг нийтэд эзэмшүүлэх нь чухал.

Т. ЦЭВЭЭН

АДУУН СҮРЭГТ АНХААРСНЫ АЧ

Батсүмбэрийн САА-н Жадамбаа даргатай адуу бригадынхан гүү бүрээс унага бойжуулах сайн арга хэрэглэж байна.

Гүүгээ унагаахаас өмнө эх төл хоёрыг нэг доор байлгах олон өрөөтэй хашаа барьж, адуучид, саальчдад адууг азарга азаргаар нь хэсэглэн маллуулснаар адууг өдөр нь хоньчлон хариулж, шөнө нь тогтмол жижүүрлэж байна.

Гүү бүрийг зүс тамгаар нь, унагалсан хээлтүүлсэн сар, өдрөөр хуанли хөтлөдгийн гадна унагалсан гүүгээ гаднаа олон та-

салгаат хашаандаа байлган ногоон өвсөөр тэжээж байна.

—Туранхай ба байдсан гүү унагаа их голдог учир ийм гүүг чөдөрлөж унагатай нь хамт нэг тасалгаанд байлган, сүүгийн нь сааж унаганд нь түрхээд уртын дууг амаар ба радиогоор уяагдуулахад уг гүү аажим номхорч унагаа хөхүүлж авах юм гэж гүүн саальчдын ахлагч эмэгтэй Хорлоо гуай ярьв.

Ингэж ажилласны үрээр 280 гүү унагалж 280 унага бойжуулж байна.

М. САМДАН

НУРГАНД ТӨГССӨН ТРАНТОРЧИН

Х. Пүрэв-Очир 1972 онд манай аймгийн шеф Курган мужид трактор комбайны 2 жилийн сургууль төгсч Баян-өнжүүл суманд тракторчноор очиж ажиллажээ.

Х. Пүрэв-Очир ярихдаа: —Би БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Г. Алтанхүү болон бусад тэргүүний тракторчдын туршлагаар техникийг үр бүтээлтэй эзэмшихэд анхаарч түүний үйлчилгээг тогтмол хугацаанд чанартай хийж, ялангуяа тосолгоог тос царцаад байхааргүй үед тосолгооны цэгүүдийг сайтар онгойлгож хийх нь чухал бөгөөд тосолгоог хэтрүүлж хийвэл зарим жийрэг мууддаг учраас хэтрүүлж хийж болохгүй.

Мөн чиргүүл машины засварыг чанартай хийж, сайн тохируулах, зүтгэх хүчтэй холбож агрегатлахдаа төвийн татах хү-

чийг зөв тохируулахыг онцлон анхаардаг юм.

Техникийн хүчин чадал бүрэн дүүрэн ашиглах нэг нөхцөл нь түлш тосны шуурийг багца цэвэр байлгахын зэрэгцээ түлшний аппаратын тохируулгыг алдагдуулахгүй нэг хэвийн байлгадаг.

Трактороор ажил гүйцэтгэж байгаа үед хөдөлгүүрийг жигд ажиллуулах нэгэн хэвийн хурдаар сааталгүй явах нь цаг хэмнэж хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх алхам болдог гэж ярьлаа.

Тракторчин Х. Пүрэв-Очир 1974 оны ажлаараа бригадын хамт олноо хошуучилж 3 удаа 1 дүгээр байр эзэлжээ.

Одоо энэ тракторчин техниктээ тосолгоо үйлчилгээ хийж хувийн бэлтгэлээ сайтар базааж үнээ даарвин их өвс хашан бэлтгэх ажилд гарахаар эзэхэж байна.

Н. ДУМАА



Зуунмод хотын 2 дугаар цэцэрлэгийн хүмүүжүүлэгч багш Баасанхүү бага насны хүүхдийн сэтгэхүйн онцлогт тохирсон олон төрлийн тоглоом, үзүүлэлт хийж ашигладаг байна.

Л. ДАМДИНДОРЖ-ийн асан гэрэл зураг

СОЦИАЛИСТ УРАЛДААНЫ ӨНӨӨГИЙН ШААРДЛАГА

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МҮЭ-ийн Төв Зөвлөл, МХЗЭ-ийн Төв Хорооноос 1973 онд бүх ард түмний социалист уралдаан зохион байгуулах тухай тогтоол гаргаснаар манай орны нийт хөдөлмөрчид социалист уралдаанд бүрэн хамрагдан ажиллаж V таван жилийн төлөвлөгөөний шийдвэрлэх жил 1973 оны улс ардын аж ахуй соёлыг хөгжүүлэх төлөвлөгөөг амжилттай биелүүлжээ.

Мөн 1974 онд бүх ард түмний социалист уралдаан дахин зохион явуулах тогтоол гаргасан билээ. Социалист уралдаан нь ард түмний гүн дундаас олон мянган авьяастнуудыг төрүүлэн өнөө үеийн баатрууд, үйлдвэрийн шинийг санаачлагчдыг олноор төрүүлэн гаргадаг байна.

Зөвхөн 1973 онд ажлаараа шалгарсан 5600 гаруй хүн нам, засгийн өндөр шагнал хүртлээ.

Тус аймгийн бүтээлч хөдөлмөрчдийн дотроос 1971—1973 онд ажлаараа шалгарч БНМАУ-ын хөдөлмөрийн баатар 8, гавь-

яат цолтон 3, улсын аварга малчин 6, аймгийн аварга 59 хүн шинээр тодрон гарав.

Социалист уралдаан нь хүнийг хүмүүжүүлэх, эдийн засгийг хөгжүүлэхэд гол тулгуур хүчин болж байна. Ю. Цэдэнбал "Социалист уралдаан бол шинэ нийгэм байгуулах арга учраас энэ хүчтэй зэвсгийг хүмүүс өдөр тутмынхаа ажилд хэрэглэвэл зохино", гэж зааснаас үзэхэд социалист уралдааны арга барил нь жилээс жилд боловсронгуй болж байх шаардлага социализмын материаллаг үйлдвэрлэлийн хөгжлийн явцаар тавигдаж байна. Иймээс үйлдвэр аж ахуйн байгууллагууд хэтийн төлөвлөгөө авсан нөхцөлд угтвар төлөвлөгөөг жил жилээр зохиож ажиллах ажилчин хүн өөрийн хэтийн ба жилийн төлөвлөгөөт даалгаврыг хүлээн хүч чадал бололцоогоо тооцоолон үзэж тооцоот үүрэг авах хувийн ажлын төлөвлөгөө зохиох.

Сэхээтнүүд эрдэм шинжилгээний болон практик ажил, төлөвлөгөөг биелүүлэх ая ч хэлбэр

рийн ажилд үр дүн гарах бүтээлч ажлын төлөвлөгөөтэй ажиллах.

—Социалист уралдааны гэрээ байгуулах.

—Материаллаг ба их төлөв сэтгэл санааны урамшлыг тухайн ажлын шаардлага технологигоос хамааруулж хугацаа хожимдуулахгүй хэрэглэж байх.

Материаллаг урамшлын шинэ системийн хөлс төлөлт, бүтээгдэхүүн борлуулалтын шагналын заавар шаардлагыг хөдөлмөрчдөд бүрэн ойлгуулах, шагнал авагчид ба хасагдлагчдыг сурталчлах зэргээр хөдөлмөрчдийн эдийн засгийн хүмүүжлийг байнга дээшлүүлэхэд чиглэдсэн ажлын арга барилыг хэрэглэх шаардлагатай юм. Зарим хүмүүс, а л б а н байгууллагууд уралдаанд үүрэг амлалт авахдаа ихээхэн шуугиан дэгдээдэг боловч эцэст нь үүрэг амлалтын биелэлт сайн биш гарвал огт чимээгүй өнгөрдөг явдлыг эцэс болгох нь зүйтэй байна. Социалист Уралдааны үүрэг боловсруулах үүрэг авах

зэрэгт ямарваа нэг өрөөсгөл хандлага, хэлбэрдэх байдлыг хэзээ ч гаргаж болохгүй юм.

Намын анхан шатны байгууллагуудын нарийн бичгийн дарга нарын улсын зөвлөлгөөнийг нээж МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ю. Цэдэнбал хэлэхдээ: "Олон түмний бүтээлч идэвхийг өрнүүлэх хүчирхэг хэрэглүүр бол аугаа их өөрчлөн байгуулагч үүрэг гүйцэтгэл нь практикаар батлагдсан социалист уралдаан, гэдгийг мартаж болохгүй, гэжээ. МАХН-ын XVI их хурлаар дэвшүүлсэн улс орны эдийн засаг соёлыг хөгжүүлэх V таван жилийн төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх явдал одоо үед нам, ард түмний нийт ажил үйлсийн гол фронт болоод байна.

Намын улс төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд, үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөдөлмөрчдийг коммунист ёсоор хүмүүжүүлэх улс орныг удирдах хэрэгт тэдний өргөн татан оролцуулах хэрэгсэл болсон социалист уралдааныг сайн зохион байгуулах ёстой байна. 1973 оны бүх ард түмний социалист уралдаанд шалгарсдын чуулга уулзалтанд МАХН-ын Төв Хорооны нарийн бич-

гийн дарга Д.Моломжамц тавьсан илтгэлдээ социалист уралдааны зохион байгуулалтыг шинэ шатанд гаргахыг зааж социалист уралдааныг хөдөлмөрийн бүтээмжийг өсгөх нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглүүлэн зохиохыг заагаад уралдаанд авсан үүргийг өдөр тутам хянах, уралдаан дүгнэх аргыг улам боловсронгуй болгох, урьд олсон амжилтаа аль хир ахиулж, дотоод нөөцийг хир зэрэг сайн дайчлан ажиллаж, ямар үр ашиг олсон ба чанарын үзүүлэлтээр уралдагчдыг шалгаруулах шаардлагатай гэж онцлон тэмдэглэснийг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Тус чуулга уулзалтанд оролцогчдоос 1974 оны социалист уралдаанд бүх нийтээр оролцож, БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойн өмнө 1974 оны улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөг II сард багтаан биелүүлэх, үүний тулд 6 өдрийн ажлыг 5 өдөрт багтаан биелүүлэх эх оронч санаачлага гарган манай орны нийт хөдөлмөрчдийг социалист уралдаанд уриалсан билээ. Энэ уриалгыг биелүүлэх нь бидний хойшлуулшгүй зорилт мөн.

Ж. МОНХТОГОО

КОММУНИЗМЫН ЭРЭНГЭЙН АЖАЛ

ЗӨВЛӨЛТ ОРНЫ БАРИЛГАЖУУЛАЛТ

ЗХУ орон сууцны барилга байгууламжийн далайцаараа дэлхийд суутай юм. Өнгөрсөн 5 жилд барилга байгууламжинд бараг 60 тэрбум рубль зарцуулжээ.

1966—1970 оны завсар хагаа тэрбум гаруй хавтгай дөрвөлжин метр талбай бүхий орон сууцны барилга барьсан байна.

Энэ нь сая хүн амтай 50 гаруй том хотыг шинээр байгуулсантай дүйх зэрэг.

Зөвлөлт засгийн жилүүдэд 4250 шахам шинэ хот, хот маягийн суурин байгуулагджээ.

Дэлхийн II дайны уршгаар 25 сая гаруй хүн орон гөргүй үлдсэн тэр үед барилга, сууцны асуудал хурд тавигдаж байсныг ЗХУ ахар богино хугацаанд амжилттай шийдвэрлэж зөвхөн сүүлийн 10 жилд Зөвлөлтийн 100 сая гаруй иргэн шинэ сууцны түлхүүр хүлээн авчээ.

Энэ бол тус орны хүн амын бараг тэн хагас нь буюу нарийвчлан хэлбэл 42 хувь нь шинэ орон сууцанд шилжин орсон юм. Одоо ЗХУ жилдээ 22 сая сууц барьж, орон сууц барих хэмжээгээр дэлхийд тэргүүнд орсон бөгөөд орон сууцны хөлс

хамгийн хямдтай орон юм. Эдүгээ Зөвлөлт оронд өдөр бүр 6—7 том үйлдвэрийн газар ашиглалтанд орж, хотууд болон ажилчны суурингуудад барагцаалбал 8000 байр, хамтралуудад 1000 байшин барьж байна.

Одоо ЗХУ-ын хот байгуулагчид байшингийн дотоод, гадаад өнгө үзэмжийг сайжруулах хот гудамжийн нүүр царайг тодорхойлж буй байшингийн гадаад байдалд анхаарлаа хандуулж байна.

ЗХУ-ын нийслэл Москва улам гоо сайхан болж тохижино. Москвад таван давхар байшингууд барихаа бараг болих ба шинэ байшингийн 95 гаруй хувь нь 9 юмуу түүнээс дээш давхар байна.

Тэдгээрийн дотор "Цамхаг хэлбэрт", байшингууд ихээхэн хувь эзлэнэ.

Хорьдугаар зуун бол төвлөрдлийн зуун юм.

Хотын хүн ам хөдөөгийнхөөс түргэн нэмэгдэж дэлхийн хүн амд түүний эзлэх хувь эрчимтэй өссөөр байгаа юм.

1900 онд дэлхий дээр 100 мянгаас дээш хүнтэй хот 800 байсан бол одоо тийм хот 2000 гаруй болж тэнд хотын нийт хүн амын гуравны хоёр шахам хувь нь аж төрж байна.

Нэн ялангуяа нэг саяас дээш хүнтэй хотууд түргэн нэмэгдэж байна.

Үүнтэй холбогдон хотын орон сууцны барилгын системийн гол зүйл нь бичил (микрo) хороолол болж байна.

Бичил хороолол бол хүмүүс аж төрж, үр хүүхдээ хүмүүжүүлэн, амарч байдаг анхан шатны бүрдэл юм. Иймээс Зөвлөлтийн хот байгуулагчид бичил хороололд аж төрөх хамгийн аятай нөхцөл бүрдүүлэхийг эрмэлзэж байна.

Үүний тул өрөө тасалгаануудад аль болох оор их нар гэрэл гэгээтүсч байхаар, бас салхи их салхилдаггүй байхаар мөн гол замаар явж байгаа тээврийн чимээ шуугиан дууллахгүй байхаар орон сууцны байшинг барьж байна.

Бичил хороололд сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага ойр зуурын хэрэгцээт бараа таваарын дэлгүүр, засварын газар, биеийн тамирын талбай, амралтын цэцэрлэг байна.

Ер нь Зөвлөлтийн хот байгуулалтын зарчим нь 1985—1990 онд хэрэгжүүлэхээр тооцогдсон Москва хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд илэрлээ олжээ. Ер нь Москваг хөгжүүлэх шинэ төлөвлөгөө бол Москвагийн төдийгүй, Зөвлөлтийн нийт хотуудын ирээдүйн хөгжлийг тусгасан хот байгуулалтын асар том программ юм.

Б. ЦЭРЭНДАШ

Байгуулагдсаны нь 50 жилийн ойд

Зөвлөлт Социалист Северо-Остины Автономит улс

Тавин жилийн тэртэй 1924 оны 7 дугаар сарын 7-нд ЗСБНХОУ-ын бүрэлдэхүүнд Северо-Остин мужийг байгуулж 1936 онд автономит улс болгон өргөтгөн байгуулжээ.

Тус улс нь Кавказын төв дунд оршдог бөгөөд 8,0 мянган хавтгай дөрвөлжин км дэвсгэр нутаг, 579,0 мянган хүн амтай.

Тус улсад ЗХУКН-ын 924 байгууллага ажиллаж түүнд 32,0 мянган коммунистууд багтдаг юм.

Тус улсын аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд өнгөт металл зонхилох суурь эзэлдэг бөгөөд үндсэн баялаг нь колметаллийн хөнгөн цагаан-цайрын хүдэр юм. Северо-Остиныхан улс орондоо хөнгөн цагаан, цайр, хүхрийн хүчил нийлүүлдэг. Электроник гэдэг заводоороо бахардагын дээр крахмал глюкоз эрдэнэшишийн тос, бурам зэрэг бүтээгдэхүүн гаргадаг. Тус улсын фабрик заводоос үйлдвэрлэн гаргадаг өнгөт болон ховор металл, хатуу хайлш, хуваах зэрэг бүтээгдэхүүнийг Зөвлөлтийн олон район хилийн гадна 30 гаруй оронд гаргадаг юм.

IX таван жилийн эхний 3 жилд аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн хэмжээ 19 хувь, хөдөлмөрийн бү-

тээмж 14,8 хувиар тус тус дээшлэж, аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний бараг 80 хувь нь хөдөлмөрийн бүтээмжийн өсөлтийн үр дүнд өсчээ. IX таван жилийн эхний 3 жилд хөдөө аж ахуйд 120 сая орчим рублийн хөрөнгө оруулжээ. Северо-Остины автономит улс нь 1973 онд 322,0 мянган тонн үр тариа хурааж улсад 146 мянган тонн үр тариа худалджээ. Тус улсын ХАА-н тэргүүний 750 сайчууд 1972—1973 онд Зөвлөлт засгийн дээд шагнал одон медаль социалист хөдөлмөрийн цол хүртжээ. Тус улсад шинжлэх ухааны доктор, дэд эрдэмтэн, профессор доцент 566 ажиллаж, арван мянган хүн тутамд 325 оюутан ноогдож, болоничуудад орчин үеийн тоног төхөөрөмж бүхий 6,6 мянган ор, 2,5 мянган их эмч, хүн эмнэлгийн дунд боловсролтой 5,4 мянган ажилтан ажиллаж Хойт-Остины автономит улсад дээд боловсролтой 12,5 мянган эмэгтэйнүүд ажиллаж байгаагийн дотор шинжлэх ухааны доктор дэд эрдэмтэн 140 байна.

Тус автономит улс нь 1964, 1972 онд Лениний болон Набармдлын одонгоор шагнуулжээ.

Н. ХАНДСҮРЭН